

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД  
ГАРСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024.07.24

Алтай хот

**Хяналт-шинжилгээний зорилго:** Аймгийн Засаг даргын 2024 оны эхний хагас жилд гарсан захирамжийн хэрэгжилтийг тодорхойлох, явцын хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг бодит мэдээллээр хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдлээ.

**Хяналт-шинжилгээний арга зүй:** Хяналт-шинжилгээг аймгийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгож, Хууль, эрх зүйн хэлтсээс нэгтгэн ирүүлсэн хэрэгжилтэд үндэслэн гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:** 2024 оны эхний хагас жилд нийт 459 захирамж гарсан бөгөөд хяналтад байгаа 360 захирамжийн хэрэгжилтийн товчоог танилцуулбал:

Хяналтад авсан захирамжийн тоо	360
Бүрэн хэрэгжсэн /100 %/	250
Хэрэгжих шатанд /70 %/	62
Хэрэгжилт хангалтгүй /30 %/	41
Хэрэгжээгүй /0 %/	4
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	3
<b>БИЕЛЭЛТИЙН ДҮН /ХУВЬ/</b>	<b>85.6</b>

“Хэрэгжээгүй” буюу “0” хувьтай 4 захирамжийн, шалтгаан:

№	Огноо, дугаар, товч утга	Захирамжийн агуулга	Шалтгаан, тайлбар
1	А/201 2024.03.20 Үнэлгээний хороо байгуулах тухай	Улсын төсвийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх элсний нүүлтийг сааруулах механик хаалт хийх гүйцэтгэгч сонгон шалгаруулах	Тендерийг зарлаагүй хүлээгдэж байна.
2	А/357 2024.05.14 Дэмжлэг үзүүлэх тухай	Аймгийн ахмад багш нарын холбооны 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 5,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлэх	Санхүүгийн баримт, шаардлагатай материал ирүүлээгүй тул гүйлгээ хийгдээгүй байна.
3	А/358 2024.05.14 Дэмжлэг үзүүлэх тухай	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн спорт өдөрлөгийн үйл ажиллагааны зардалд 2,663,600 төгрөгийн дэмжлэг үзүүлэх	Санхүүгийн баримт, шаардлагатай материал ирүүлээгүй тул гүйлгээ хийгдээгүй байна.
4	А/410 2024.06.07 Үнэлгээний	“Ахмадын холбоо, сувиллын барилга” угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх	2024 оны төсвийн тухай хуулинд батлагдсан дүн нь Төрийн аудитын

	хороо байгуулах тухай	гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах	нэгдсэн дүнтэй зөрсөн тул ХНХЯ-д шийдвэрлүүлэхээр санал хүргүүлсэн боловч хариу ирээгүй хүлээгдэж байна.
--	-----------------------	----------------------------------	--

## ДҮГНЭЛТ

Аймгийн Засаг даргын 2024 оны хагас жилийн байдлаар гарсан захирамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж дараах дүгнэлтийг гаргаж байна.

1.Аймгийн Засаг даргын 2024 оны хагас жилийн байдлаар гарсан 459 захирамжаас хяналтад байгаа 360 захирамжийн 250 нь 100 %, 62 нь 70 %, 41 нь 30 %, 4 нь 0 %-тай, 3 нь “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” үнэлэгдэж, хэрэгжилтийн дундаж 85.6 хувьтай байна.

2.Хяналтад байгаа 360 захирамжийн 69.4 хувь нь бүрэн хэрэгжсэн, 17.2 хувь нь хэрэгжих шатанд, 11.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй байна. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа удаашралтай, удирдлага зохион байгуулалт дутагдалтайгаас 3 захирамжийн хэрэгжилт хангалтгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргын 2024 оны хагас жилийн байдлаар гарсан захирамжийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

### Нэг. Хууль, эрх зүйн хэлтэст:

1.Зарим захирамжийн хэрэгжилтийг тайлагнахдаа өмнөх улирлын хэрэгжилтийг хэвээр бичсэн, нэмэлт өөрчлөлтийг хийгээгүй дутагдал байх тул цаашид анхаарч, эцсийн гүйцэтгэлээр тайланг нэгтгэхэд анхаарах;

### Хоёр. Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

1.Эрхлэх асуудлын хүрээнд хэлтэст болон харьяа агентлагт хамаарах захирамжийн хэрэгжилтийг тухай бүр хангуулах, “хэрэгжилт хангалтгүй”, “хэрэгжээгүй” захирамжийг хэрэгжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах;

2.“Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн А/05, А/12, А/13, А/14, А/15, А/17, А/19, А/21, А/22, А/23, А/24, А/25, А/26, А/27, А/28, А/29, А/30, А/31, А/34, А/37, А/41, А/42, А/43, А/44, А/45, А/48, А/49, А/80, А/177, А/278, А/288, А/289, А/297, А/314, А/408, “хэрэгжээгүй” үнэлэгдсэн А/201, А/410 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

### Гурав. Нийгмийн бодлогын хэлтэст:

1.“Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн А/133, А/303, А/306, А/383, А/429, А/431, “хэрэгжээгүй” үнэлэгдсэн А/357, А/358 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх арга хэмжээ авах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

